



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/66

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монголын Улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 10 дугаар зүйлийн 10.1, Засгийн газрын 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 234 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 08 дугаар сарын 29-ний “Хөтөлбөр батлах тухай” 56 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 3.5.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүмүүнлэгийн чиглэлээрх төрийн зарим чиг үүргийг аймгийн Улаан загалмайн хороогоор гүйцэтгүүлэхэд 22,000,000 (хорин хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.2. Аймгийн Улаан загалмайн хороотой 2024 онд хамтран ажиллах гэрээг байгуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т үүрэг болгосугай.

3. Дээрх 22,000,000 (хорин хоёр сая) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И. ДОРЖСҮРЭН

6224 11 0139